



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар Б/14

Буянт

Ээлжийн амралт олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, 99.3, 99.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын төвийн дарга ажилтай С.Мөнхтогоогийн 2024 оны ээлжийн амралтыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүртэл олгосугай.

2. Амралтын мөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бодож олгохыг байгууллагын Нягтлан бодогч (А.Отгонцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Пэрэнлэй)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЛХАГВАДОРЖ

642401075



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 5/13

Буянт

Д.Сармандахад гуравдугаар улирлын
үр дүнгийн урамшуулал олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, 59.1.23, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам батлах" тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.6, 3.12, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн дарга ажилтай Дуламын Сармандахад гуравдугаар улирлын ажлын тайлан, ажлын хэсгийн үнэлгээг үндэслэн ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг бодож олгосугай.

2. Д.Сармандахад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 45 хувиар тооцон, 10 дугаар сарын цалинд бодож олгохыг Нягтлан бодогч (Д.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Санхүү албаны дарга (Б.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д. ЛХАГВАДОРЖ



642401057